

БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН  
СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ  
ХИЙХ УДИРДАМЖ

**Үндэслэл:**

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 3.4.25 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 97/56 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 5.1 дэх заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын 2019 оны А/32 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийхээр энэхүү удирдамжийг боловсрууллаа.

**Зорилго:**

Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын сургалтын явцад үнэлгээ хийж, суралцагч эмч нартай уулзалт хийх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж боловсруулж хүргүүлэх зорилготой.

**Зорилт:**

- Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг үнэлэх
- Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагын сургалтын орчинг үнэлэх
- Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага дээрх суралцагчдын дэмжлэгт орчинг үнэлэх
- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг үнэлэх
- Суралцагч-эмчид зааж чиглүүлэх тогтолцоог үнэлэх
- Суралцагч эмчийн үнэлгээг үнэлэх

**Хамрах хүрээ:**

- Улсын нэгдүгээр төв эмнэлэг
- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Зоонозын өвчин судлалын үндэсний төв
- Гэмтэл согог судлалын үндэсний төв
- Эмгэг судлалын үндэсний төв
- Хавдар судлалын үндэсний төв
- Нийслэлийн Өргөө амаржих газар
- Нийслэлийн Амгалан амаржих газар
- Цэргийн төв эмнэлэг

- Ачтан эмнэлэг  
**Үнэлгээ хийх хугацаа:**
- 2020 оны II-IV улиралд

**Үнэлгээний хуваарь:**

№	Сургалт эрхлэх байгууллага	Үнэлгээ хийх хугацаа
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	4 сар
2	Халдварт өвчин судлалын үндэсний төв	3 сар
3	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	4 сар
4	Гэмтэл согог судлалын үндэсний төв	5 сар
5	Эмгэг судлалын үндэсний төв	2 сар
6	Хавдар судлалын үндэсний	11 сар
7	Нийслэлийн Өргөө амаржих газар	10 сар
8	Нийслэлийн Амгалан амаржих газар	11 сар
9	Цэргийн төв эмнэлэг	9 сар
10	Ачтан эмнэлэг	6 сар

**Үнэлгээ хийх бүрэлдэхүүн:**

Үнэлгээний багийн ахлагч  
Гишүүд

Н.Сэвжид, ХНБЗА-ны дарга  
П.Эрхэмбаяр, ХНБЗА-ны ахлах мэргэжилтэн  
Я.Бадамсүрэн, ХНБЗА-ны мэргэжилтэн  
Д.Баярхүү, ХНБЗА-ны мэргэжилтэн  
Г.Гэрэлмаа, ЭХЭМҮТ-ийн сургалтын албаны  
дарга /зөвшилцсөнөөр/  
В.Баярмаа, СЭМҮТ-ийн НЭМСЭШХ дэд  
захирал /зөвшилцсөнөөр/  
Ж.Жавхаа, Нийслэлийн ЧД-ийн ЭМТ-ийн  
сургалтын албаны дарга //зөвшилцсөнөөр/

**Үнэлгээ хийх зарчим:**

Үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2019 оны 03 сарын 29-ний өдрийн А/32 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан үнэлгээний шалгуурын дагуу үнэлнэ.

Үнэлгээний үзүүлэлтийн зохион байгуулалт: 3 үе шатаас бүтнэ.

- Ерөнхий үзүүлэлт
- Дэд үзүүлэлт
- Нарийвчилсан үзүүлэлт

Дэд үзүүлэлтээр үнэлэх

3 үе шатаар дүгнэнэ.

- Зохистой - Сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байгаа, үйл ажиллагаа тогтмолжсон.
- Гүйцээх шаардлагатай - Зарим ажил зохион байгуулалтад орсон ч нэмж гүйцээх шаардлагатай.
- Сайжруулах шаардлагатай - Сайжруулах шаардлагатай ажил байна.

## Нарийвчилсан үзүүлэлт

1. Нарийвчилсан үзүүлэлтэд “a / b / c” гэсэн 3 үнэлгээ өгнө.

“a” Сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа, хэвшсэн, үнэлгээ хийх боломжтой.

“b” Зарим ажил зохион байгуулалтад орсон, үнэлгээ хийх боломжтой.

“c” Үйл ажиллагаа тогтмолжоогүй, хэвшил болоогүй, үнэлэхэд хүндрэлтэй.

Нарийвчилсан үзүүлэлтийг харгалзан үзэж, дэд үзүүлэлтийг үнэлнэ.

- Зохистой - Сургалтыг зохих журмын дагуу зохион байгуулж байгаа
- Судлах шаардлагатай - Зарим нэг хэсгийн ажил зохион байгуулалтад орсон ч судалж үзэх шаардлагатай, гүйцээх зүйлс байна.
- Сайжруулах шаардлагатай - Нэн даруй сайжруулах шаардлагатай зүйлс байна.

Нарийвчилсан үнэлгээнд “чухал” гэж үзсэн үзүүлэлтийг харгалзан дэд үзүүлэлтийн үнэлгээг нэгтгэж тооцно.

### **Үр дүн:**

1. Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагын сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчинд явцын үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулж, хүргүүлсэн байна.
2. Сургалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангасан байна.

Хянасан:

Боловсруулсан:

*Н. Сэвжид*  
*П. Эрхэмбаяр*

Н.Сэвжид /ХНБЗА-ын дарга

П.Эрхэмбаяр /ХНБЗА ахлах

мэргэжилтэн/